



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Аудитын код: САГ-2021/3/СТА-ТЭЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p> | <p>Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamyia@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Долгоржав Утас: 261740 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 3. Аудитын тайлан..... | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 10 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.... | 11 |
| 3.4 Материаллаг байдал | 11 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 13 |
| 3.8 Аудитын гол асуудал | 13 |
| 3.9 Шилэн дансны мэдээлэл..... | 14 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 14 |
| 4. Аудитын илрүүлэлт | 15 |
| 5. Менежментийн захидал..... | 16 |
| 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 18 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1319

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A square red stamp containing a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'.

Д.ЗАНДАНБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Тайлангийн үзүүлэлт | 2019 оны 12-р сарын 31 | 2020 оны 12-р сарын 31 |
|---|------------------------|------------------------|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 45,850.5 | 109,880.6 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 20.8 | 21,017.8 |
| АВЛАГА | 3,114.8 | 14,770.7 |
| БАРАА МАТЕРИАЛ | 42,714.9 | 74,092.1 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 8,262,806.1 | 7,984,252.3 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 8,262,806.1 | 7,984,252.3 |
| Биет хөрөнгө | 6,927,873.0 | 6,754,784.2 |
| Биет бус хөрөнгө | 1,334,933.1 | 1,229,468.1 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 8,308,656.6 | 8,094,132.9 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | 5,387.9 | 1,829.2 |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 5,387.9 | 1,829.2 |
| Өглөг | 5,387.9 | 1,829.2 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,303,268.7 | 8,092,303.7 |
| Засгийн газрын хувь оролцоо | 8,303,268.7 | 8,092,303.7 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,080,671.2 | 2,080,671.2 |
| Хуримтлагдсан үр дүн | 4,665,308.5 | 4,454,343.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,557,289.1 | 1,557,289.1 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 8,308,656.6 | 8,094,132.9 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Тайлангийн үзүүлэлт | 2019 оны 12-р сарын 31 | 2020 оны 12-р сарын 31 |
|--|------------------------|------------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 7,828,868.3 | 2,686,596.2 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,135,093.9 | 28,861.0 |
| Нийтлэг татварын бус орлого | 0.0 | 28,861.0 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,135,093.9 | 0.0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,693,774.3 | 2,657,735.2 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,818,207.3 | 2,543,077.9 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,481,040.6 | 2,543,077.9 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,448,203.9 | 2,516,264.9 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,177,936.3 | 1,325,165.6 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 142,828.4 | 165,301.2 |
| Хангамж, бараа материалын зардал | 50,338.7 | 63,276.3 |
| Нормативт зардал | 168,709.4 | 160,438.7 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 88,495.6 | 52,015.0 |
| Томилолт, зочны зардал | 92,000.0 | 8,968.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 161,524.5 | 48,294.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 566,371.2 | 692,804.8 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 32,836.7 | 26,813.0 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 337,166.7 | 0.0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 5,010,661.0 | 143,518.3 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 246,620.0 | 359,480.0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 4,764,041.0 | (215,961.7) |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|--|--|-----------------------|------------------------|
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,539,227.7 | 0.0 | 3,539,227.7 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,539,227.7 | 0.0 | 3,539,227.7 |
| Тайлант үеийн үр дүн | 4,764,041.0 | 0.0 | 4,764,041.0 |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,303,268.7 | 0.0 | 8,303,268.7 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 4,996.7 | 0.0 | 4,996.7 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,308,265.4 | 0.0 | 8,308,265.4 |
| Тайлант үеийн үр дүн | (215,961.7) | 0.0 | (215,961.7) |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,092,303.7 | 0.0 | 8,092,303.7 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Тайлангийн үзүүлэлт | 2019 оны 12-р сарын 31 | 2020 оны 12-р сарын 31 |
|--|------------------------|------------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,693,824.5 | 2,679,127.9 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 50.2 | 21,392.7 |
| Нийтлэг татварын бус орлого | 50.2 | 21,392.7 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,693,774.3 | 2,657,735.2 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,066,326.1 | 1,982,004.8 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,066,326.1 | 1,982,004.8 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,985,082.3 | 1,952,946.1 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,127,170.1 | 1,340,426.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 139,869.9 | 151,330.3 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 50,338.7 | 63,276.3 |
| Хангамж, бараа материалын зардал | 185,206.1 | 159,234.7 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 89,644.6 | 60,211.4 |
| Томилолт, зочны зардал | 100,000.0 | 8,968.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 156,243.9 | 70,379.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 136,609.0 | 99,119.1 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81,243.8 | 29,058.7 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 627,498.4 | 697,123.1 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 627,498.4 | 676,126.1 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 627,498.4 | 676,126.1 |
| Дотоод эх үүсвэрээр | 627,498.4 | 676,126.1 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (627,498.4) | (676,126.1) |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0.0 | 20,997.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 20.8 | 20.8 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 20.8 | 21,017.8 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|-----------------------|------------------|------------------|-------------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,899,216.1 | 2,657,735.2 | 241,480.9 | 96.7 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,314,216.1 | 2,074,885.2 | 239,330.9 | 89.7 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,046,222.2 | 2,046,222.2 | 0.0 | 100.0 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,340,426.0 | 1,340,426.0 | 0.0 | 100.0 |
| Үндсэн цалин | 850,153.7 | 850,153.7 | 0.0 | 100.0 |
| Нэмэгдэл | 402,882.5 | 362,495.7 | 40,386.8 | 90.0 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 45,019.3 | 31,316.7 | 13,702.6 | 69.6 |
| Урамшуулал | 42,370.5 | 96,459.9 | (54,089.4) | 227.7 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 151,330.3 | 151,330.3 | 0.0 | 100.0 |
| Тэтгэврийн даатгал | 106,491.6 | 106,491.6 | 0.0 | 100.0 |
| Тэтгэмжийн даатгал | 11,209.7 | 11,209.7 | 0.0 | 100.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 8,967.8 | 8,967.8 | 0.0 | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 2,241.9 | 2,241.9 | 0.0 | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 22,419.3 | 22,419.3 | 0.0 | 100.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 63,276.3 | 63,276.3 | 0.0 | 100.0 |
| Гэрэл, цахилгаан | 42,585.6 | 44,128.3 | (1,542.7) | 103.6 |
| Түлш, халаалт | 10,467.3 | 9,968.9 | 498.4 | 95.2 |
| Цэвэр, бохир ус | 10,223.4 | 9,179.1 | 1,044.3 | 89.8 |
| Хангамж, бараа материалын зардал | 167,353.8 | 167,353.8 | 0.0 | 100.0 |
| Бичиг хэрэг | 13,609.3 | 13,609.3 | 0.0 | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 95,000.0 | 95,000.0 | 0.0 | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 29,908.1 | 29,908.1 | 0.0 | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,873.4 | 1,873.4 | 0.0 | 100.0 |
| Ном хэвлэл | 22,433.9 | 22,433.9 | 0.0 | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,529.1 | 4,529.1 | 0.0 | 100.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 69,368.9 | 69,368.9 | 0.0 | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 2,888.9 | 3,514.0 | (625.1) | 121.6 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,078.3 | 7,078.3 | 0.0 | 100.0 |
| Урсгал засвар | 59,401.7 | 58,776.6 | 625.1 | 98.9 |
| Томилот, зочны зардал | 8,968.7 | 8,968.7 | 0.0 | 100.0 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 8,968.7 | 8,968.7 | 0.0 | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 125,032.7 | 125,032.7 | 0.0 | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 62,036.2 | 62,036.2 | 0.0 | 100.0 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 61,000.0 | 61,000.0 | 0.0 | 100.0 |
| Газрын төлбөр | 1,996.5 | 1,996.5 | 0.0 | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 120,465.5 | 120,465.5 | 0.0 | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3,871.5 | 3,871.5 | 0.0 | 100.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 116,594.0 | 116,594.0 | 0.0 | 100.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 267,993.9 | 28,663.0 | 239,330.9 | 10.7 |
| Засгийн газрын гадаад шилжүүлэг | 2,963.0 | 2,963.0 | 0.0 | 100.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 265,030.9 | 25,700.0 | 239,330.9 | 9.7 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 239,330.9 | 0.0 | 239,330.9 | 0.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 25,700.0 | 25,700.0 | 0.0 | 100.0 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 585,000.0 | 582,850.0 | 2,150.0 | 99.6 |
| Дотоод эх үүсвэр | 585,000.0 | 582,850.0 | 2,150.0 | 99.6 |

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | |
|---|-------------|-------------|-----------|-------|
| Тоног төхөөрөмж | 585,000.0 | 582,850.0 | 2,150.0 | 99.7 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,899,216.1 | 2,657,735.2 | 241,480.9 | 91.7 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,899,216.1 | 2,657,735.2 | 241,480.9 | 91.7 |
| Улсын төсвөөс санхүүжих | 2,314,216.1 | 2,074,885.2 | 239,330.9 | 89.6 |
| Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 585,000.0 | 582,850.0 | 2,150.0 | 99.6 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 20.8 | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 21,017.8 | | |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | 100.0 |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100.0 |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 49 | 49 | | 100.0 |
| Удирдах ажилтан | 10 | 10 | | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 33 | 33 | | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 6 | 6 | | 100.0 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийн дагуу хөрөнгийг зарцуулах, бэлэн мөнгөний зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын аудитор Б.Долгоржав гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ТГ-1/129 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.

Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргаан магадлан шийдвэрлэх, Тамгын газар нь Үндсэн хуулийн цэцийн үндсэн зарчим, бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт, судалгаа, мэдээллээр хангах, захиргаа, удирдлага зохион байгуулах чиг үүргүүдийг гүйцэтгэдэг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал, ажиллах хэвийн нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Тамгын газар захиргаа, хүний нөөцийг хангах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомж, шийдвэрийн биелэлт, гадаад харилцаа, мэдээллийн технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2019 оны 11 дүгээр сард Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Парламентын ардчиллыг төлөвшүүлэх, засаглах эрхийг хангах, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангах, нутгийн удирдлагыг бэхжүүлэх гэх мэт өөрчлөлтүүдийг оруулж батлан, 2020 оны 5 дугаар сараас улс даяар мөрдөж эхэлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 8,094.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 80.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 214.5 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------|----------------|-----------------|---------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 21.0 | 21.0 |
| Авлага | 3.1 | 14.8 | 11.7 |
| Бараа материал | 42.7 | 74.1 | 31.4 |
| Үндсэн хөрөнгө | 8,262.8 | 7,984.2 | -278.6 |
| Нийт хөрөнгө | 8,308.6 | 8,094.1 | -214.5 |

| | | | |
|---|----------------|----------------|---------------|
| Өр төлбөр | 5.2 | 1.8 | -3.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 8,303.4 | 8,092.3 | -211.1 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 8,308.6 | 8,094.1 | -214.5 |

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 21.0 сая төгрөг болж өмнөх оны үзүүлэлтээс 21.0 сая төгрөгөөр өссөн нь Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Авлага данс оны эцэст 14.8 сая төгрөг болж, өмнөх оны үзүүлэлтээс 11.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт авлагын 14.7 сая төгрөг байгууллагаас авах бараа үйлчилгээний авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 74.1 сая төгрөг болж, өмнөх оноос 31.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг таниулах сургалт сурталчилгааны материал, галын аюулгүй байдал, эмнэлгийн анхан тусламж, аж ахуйн материалууд бэлтгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын бүртгэл дэх 30.9 сая төгрөгийн хөрөнгүүд нь өмнөх жилүүдэд бэлтгэсэн байгууллагын аж ахуйн хэрэгслүүд байна.

Үндсэн хөрөнгө данс оны эцэст 7,984.2 сая төгрөг болж, өмнөх оноос 278.6 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд хөрөнгө оруулалтаар 582.8 сая, урсгал төсвийн хөрөнгөөр 93.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ТӨБЗГ-ын 2019 оны А-4/195 дугаар тогтоолын дагуу 35.3 сая төгрөгийн хөрөнгүүдийг акталсан ба үнэ төлбөргүй 368.8 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 1,229.5 сая төгрөг болж өмнөх оны үзүүлэлтээс 105.5 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

Өглөг данс оны эцэст 1.8 сая төгрөг болж, өмнөх оноос 3.4 сая төгрөгөөр буурсан ба байгууллагад төлөх өглөг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 5,142.3 сая төгрөгөөр буюу 2.9 дахин буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 275.1 сая төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн хязгаарын саналд урсгал зардал 3,186.9 сая, хөрөнгийн зардлыг 5,779.0 сая буюу нийт 8,965.9 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлсэн ба Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Үндсэн хуулийн цэцийн төсөв 2,899.2 сая төгрөгөөр батлагдсан байна.

Тайлант онд дээрх төсвийг ТЕЗ-ын хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,657.7 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,074.9 сая, хөрөнгийн зардалд 582.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Гүйцэтгэл 96.7 хувьтай байгаа нь хөрөнгийн зардал 2.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн, бусад урсгал шилжүүлгийн 239.3 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, урсгал шилжүүлэг, томилолт, эд хогшил урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардлууд нийт 574.7 сая төгрөгөөр буурсан, харин байр ашиглалт болон хөрөнгийн зардал нийт 116.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-д нийцэж байгаа боловч маш ерөнхий байна. Энэ талаар өмнөх оны аудитын тайланд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах шаардлагатайг дурдсан бөгөөд тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг шалгаж, Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, арга зүйг мөрдөн, аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Коронавируст халдварын цар тахал дэгдэлтийн улмаас Засгийн газраас 2020 онд гаргасан тогтоолуудаар улсын хэмжээнд бүх нийтийн өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэг тогтоосонтой холбоотойгоор Үндсэн хуулийн цэцийн даргын 2020 оны 06 дугаар тушаалаар Үндсэн хуулийн цэц, Тамгын газрын үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлэн ажилласан байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан хамгаалах хэрэглэлд 8.9 сая, ариутгал халдваргүйжүүлэлтэд 5.0 сая, дархлаажуулалт 2.9 сая төгрөг буюу нийт 16.9 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хуулийн цэц нь 2020 онд Бага суудлын хуралдаан 24, Дунд суудлын хуралдаан 10, Их суудлын хуралдаан 1, нийт 35 хуралдаан хийсэн байна. Тайлант хугацаанд Үндсэн хуулийн цэц 188 өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, урьд оны үлдэгдэл 48, нийт 236 өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлтийг хянаж шалган Үндсэн хуулийн цэцийн гишүүний 166 тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 27 магадлал, 10 дүгнэлт, 1 тогтоол тус тус гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар 2020 онд 3 бүлэг, 25 зорилт, 125 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөснөөс төрийн албан хаагчдад зориулсан танхимын сургалт, гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа коронавируст халдвар дэгдсэнтэй холбоотойгоор хэрэгжээгүй байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 148 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 32 удаагийн 782.8 сая төгрөгийн ажил гүйлгээг байршуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 17.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн 1 акт тогтоож, 9.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтахгүй ажиллах талаар өгсөн 13.5 сая төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 54.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Гүйцэтгэлийн хувь |
|-----------------|---------------------|-------------|----------|-------------|-------------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Акт | 1 | 17.4 | 1 | 17.4 | 100 |
| Албан шаардлага | 1 | 9.5 | 1 | 9.5 | 100 |
| Зөвлөмж | 4 | 13.5 | 4 | 7.4 | 54.8 |
| Нийт дүн | 5 | 40.4 | 5 | 34.3 | 84.9 |

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй, тайлант онд 76.4 сая төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорилын үр дүнд дараагийн аудитаар дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Санхүүгийн тайланд хийсэн аудитаар цар тахлын нөхцөл байдлын улмаас хөрөнгийн үлдэгдэлд хэсэгчилсэн тооллого биет тест хэрэгжүүлж амжаагүй тул дараагийн аудитаар нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэх;
- Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг шалгаж үнэлэх ажлыг гүйцэтгэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 111.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 35.1 сая төгрөгийн алдааг залруулан, 76.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ахмадын сангийн үлдэгдэл 20.9 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн зарлагаар бүртгэсэн.
2. Бараа материалын дансанд 14.2 сая төгрөгийн бараа материалыг шинж чанараар буруу ангилан бүртгэснийг тус тус залруулга хийлгэж бүртгүүлсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 76.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн урсгал засварын зардлаас 2.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 23.6 сая, мэдээлэл технологийн зардлаас 1.8 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 48.6 сая, нийт 76.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

5. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Харилцах дансаар хийх бололцоотой 43.2 сая төгрөгийг кассаар дамжуулан бэлнээр гүйцэтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл

Мөнгөн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сул байх, "Мөнгөн кассын ажиллагааны журам" болон холбогдох хууль, журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Бэлэн мөнгөний зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, "Мөнгөн кассын ажиллагааны журам"-ын холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Илэрсэн алдаа зөрчлүүдийг байгууллагын удирдлагад танилцуулсан.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төсвийн зохицуулалт хийх Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас 14.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 14.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, 11.7 сая төгрөгийн программ хангамжийг зардлын зориулалтыг зөрчин бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсвийг хэтрүүлэн зарцуулах, төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчин зарцуулах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг үндэслэлтэй боловсруулан батлуулах, батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Илэрсэн алдаа зөрчлүүдийг байгууллагын удирдлагад танилцуулсан.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тендерт шалгарсан компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах шийдвэр гаргаагүй байхад гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т "Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг,

материалаас бүрдэнэ", 49.2.8-д "гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагаанд холбогдох хуулийг мөрдөж ажиллаагүй байх, ашиг сонирхол үүсэх, анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллаагүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг хангах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.8 дахь заалтыг мөрдөж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Илэрсэн алдаа зөрчлүүдийг байгууллагын удирдлагад танилцуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хавсралт

| | | |
|--|--|---|
| Огноо: 2020 он | Аудитын нэр: Үндсэн хуулийн цэцийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: САГ-2021/3/СТА-ТЕ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: Монгол Улсын Үндсэн хуулийн цэц | Мөнгөн дүн: 76.4 сая төгрөг | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|------------|---|-------------|---------------------------------------|---|-------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | |
| 1 | Батлагдсан төсвийн урсгал засварын зардлаас 2.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 23.6 сая төгрөг, мэдээлэл технологийн зардлаас 1.8 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 48.6 сая төгрөг, нийт 76.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан | 76.4 | Албан шаардлага хүргүүлэх | | |
| 2 | Харилцах дансаар хийх бололцоотой 43.2 сая төгрөгийг кассаар дамжуулан бэлнээр гүйцэтгэсэн байна. | 0.0 | Зөвлөмж өгөх | Тамгын газрын дарга | Д.Баянбилэг |
| 3 | Төсвийн зохицуулалт хийх Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас 14.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 14.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, 11.7 сая төгрөгийн программ хангамжийг зардлын зориулалтыг зөрчин бэлтгэсэн байна. | 0.0 | Зөвлөмж өгөх | Ахлах нягтлан бодогч | Б.Эрдэнэбат |
| 4 | Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тендерт шалгарсан компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах шийдвэр гаргаагүй байхад гэрээ байгуулсан байна. | 0.0 | Зөвлөмж өгөх | | |
| ДҮН | | 76.4 | | | |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 342/АДН10001

Улаанбаатар хот

САГ-2021/3/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн урсгал засварын зардлаас 2.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 23.6 сая, мэдээлэл технологийн зардлаас 1.8 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 48.6 сая төгрөг нийт 76.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулах, тогтоосон ангиллын дагуу төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат, Тамгын газрын дарга Д.Баянбилэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.2020\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0426auditin 2-R Газар12.Docx

001081246